


**“Монгол улсын гадаад худалдааны бодлогод  
анхаарах асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийн  
хураангуй**



**“МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГОД  
АНХААРАХ АСУУДЛУУД”**

| 2018 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР  
УЛААНБААТАР ХОТ





**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

# **МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГОД АНХААРАХ АСУУДЛУУД**

**2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр**

# АГУУЛГА

Нээлтийн үг	- Н.Баяртсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч.....	5
	- Б.Баттөмөр, Монгол улсын их хурлын гишүүн.....	6
Илтгэл	- Д.Ган-Очир, Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал.....	7
	- С.Дэмбэрэл, Монголбанкны дэргэдэх Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал.....	9
Хэлэлцүүлэг	- Монгол улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд.....	10



Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье!

Бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Монголын гадаад худалдааны гол зохицуулагч, оролцогч байгууллагуудын төлөөлөл, эрхэм зочид, төлөөлөгч Та бүхэндээ талархлаа илэрхийлье!

Монголбанкнаас эдийн засгийн бодлогын асуудлыг хөндсөн хурал, хэлэлцүүлгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын мэргэжилтэн, эрдэмтэд, судлаачдыг хамруулан өргөн хүрээнд тогтмол зохион байгуулж байгаа билээ. Энэ удаагийн ээлжит хэлэлцүүлэг нь манай улсын гадаад худалдааны бодлого, түүнд тулгарч буй саад бэрхшээл, анхаарах асуудлын талаар хамтдаа нэгдсэн ойлголтод хүрч, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын чиглэл, үндэс суурийг тодорхойлоход оршиж байна.

Дэлхийн хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнууд гадаад худалдааны орлого, түүний үр өгөөжид тулгуурлан эдийн засгаа хөгжүүлэх, тэлэх шаардлага зайлшгүй тулгарч байна. Учир нь өнөөгийн даяарчлагдсан нийгэмд улс орнуудын эдийн засаг, хөгжилд олон улсын худалдаа, хамтын ажиллагаа их хэмжээгээр нөлөөлж байна. Тухайлбал экспортын орлого нь тухайн улсын эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, валютын ханшийн тогтвортой байдал болон гадаад өрийн тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Түүнчлэн Монгол улс хангалттай хэмжээний гадаад валютын нөөц бүрдүүлэх нь эдийн засгийн аюулгүй байдал, тусгаар тогтнолын санхүүгийн баталгаа тул валютынхаа нөөцийг байнга нэмэгдүүлэх бодлого баримтлах учиртай. Хэдийгээр гадаад валютын нөөц нэмэгдэж 3 тэрбум ам.доллар буюу импортын 6 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн хэдий ч, түүний хүрэлцээт түвшинг нэмэгдүүлэх бодлого чухал хэвээр байна. Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх нь бодлогын асуудал бөгөөд Монголбанк дангаар хийж хүч хүрэх ажил биш юм. Гадаад валютын нөөцийг дорвитой нэмэгдүүлэхдээ гадаад өрөөр бус, төлбөрийн тэнцлийн урсгал дансны ашгаар нэмэгдүүлэх нь илүү үр дүнтэй. Үүнд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого чухал үүрэгтэй. Монголчууд бид худалдаа, арилжаагаар амьжиргаагаа зохицуулан амьдарч байгаа атлаа тодорхой үр дүнд хүрсэн гадаад худалдааны цогц бодлогогүй, энэ асуудлыг дангаар хариуцсан яамгүй явж ирлээ. Ялангуяа дэлхийд "худалдааны маргаан", худалдааны дайн эхэлж буй энэ цаг үед ингэж амирлангуй сууж таарахгүй. Мөн Дэлхийн Худалдааны Байгууллагатай сүүлийн жилүүдэд харилцаа хэрэг дээрээ зогсонги байдалд оров.

Иймээс Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид та бүхнээс Монгол улсын гадаад худалдааны бодлогын асуудал, цаашид хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөөний талаар эрдэм, оюунаа чилээн, мэдлэг, туршлагаа хуваалцан, хувь нэмрээ оруулахыг хүсч байна.

Та бүхэнд баярлалаа!



**Н.Баяртсайхан**  
Монголбанкны Ерөнхийлөгч

Монголчууд бид худалдаа, арилжаагаар амьжиргаагаа зохицуулан амьдарч байгаа атлаа тодорхой үр дүнд хүрсэн гадаад худалдааны цогц бодлогогүй, энэ асуудлыг дангаар хариуцсан яамгүй явж ирлээ.

Энд хуран цугларсан та бүхний амар амгаланг айлтгая!

Монголбанкнаас зөв зүйтэй асуудлыг дэвшүүлсэн хэлэлцүүлгүүдийг тогтмол зохион байгуулж байна. Монголбанкны холбогдох газруудаас хийж буй судалгаа шинжилгээний ажлууд нь бодлого боловсруулагчдад чухал ач холбогдолтой мэдээллийг агуулж байдаг.

Монгол улсад бизнес эрхлэх нөхцөл хүнд байна. Зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш зохицуулалтгүй худалдаа нэмэгдсэн. Зарим статистик тоо баримт дурдвал: Нийт худалдаа эрхэлж буй хүмүүсийн 45 орчим хувь нь зориулалтын байр байхгүй, түргэн чанарын бараа худалддаг хүмүүсийн 40 орчим хувь нь зориулалтын тоног төхөөрөмжгүй, тээврийн чиглэлээр бизнес эрхэлж байгаа байгууллагуудын 50 орчим хувь нь зориулалтын бус тээвэрлэлттэй байна.

Түүнчлэн Монгол улсад бүтээгдэхүүний чанарын хяналт маш муу байдаг. Иймд хямд, чанар муутай барааг импортолдог асуудлыг зохицуулах шаардлага бий.

Монгол улс нь худалдааны цогц хуульгүй учир худалдаа эрхлэгчид бүртгэлгүй байна. Гэтэл худалдаа эрхэлж буй хүмүүсийг бүртгэн, статистик тоо мэдээг гаргаж, үүн дээр тулгуурлан бодлого боловсруулж байх ёстой. Энэ процесс дутагдаж байна. Мөн гадаад худалдааны чиглэлээр дагнасан яам шаардлагатай гэдэг асуудал дээр Монголбанктэй санал нэг байгаа.

Нэгтгэж хэлэхэд худалдааны цогц хуулийг гаргая, зохицуулалтын системтэй болъё, худалдаа эрхлэгчдийг бүртгэлжүүлье, чанаргүй бараа бүтээгдэхүүний импортыг зогсооё, экспортыг дэмжих арга хэмжээг илүү хүртээмжтэй хэрэгжүүлье.

Та бүхний ажилд амжилт хүсье. Баярлалаа!



**Б.Баттөмөр**

Монгол Улсын Их Хурлын  
Гишүүн

Гадаад  
худалдааны  
чиглэлээр  
дагнасан яам  
шаардлагатай  
байгаа гэдэгт  
Монголбанктэй  
санал нэг  
байна.

Тухайн орны гадаад валютын нөөцөөс улс орны эдийн засгийн аюулгүй байдал, дархлаа шууд хамаарна. Тухайлбал, гадаад валютын нөөц нь төгрөгийн ханш тогтвортой байх, хүү буурах, инфляци тогтворжих, санхүүгийн эрсдэл даах чадвар нэмэгдэх болон зээлжих зэрэглэл дээшлэх зэрэгт чухал нөлөөтэй.

Дэлхийн хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнууд гадаад худалдааны орлогод тулгуурлан эдийн засгаа тэлэх, хөгжүүлэх шаардлагатай тулгарч байна. Олон улсын худалдаа, экспорт болон импортын хэмжээг улс орнууд гадаад худалдааны бодлогоор дамжуулан удирддаг. Гадаад худалдааны тухайн улсын эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө өндөр байхад бодлогыг хэрэгжүүлэх институцийн чадавх, хүний нөөцийн чадавх, улс төрийн буюу бодлогын тогтвортой байдал болон оновчтой тодорхойлогдсон бодлого зэрэг нь ихээхэн ач холбогдолтой юм.

Гадаад худалдаанд тулгуурлан хөгжсөн орнуудын жишээг харахад худалдааны бодлогыг бие даасан яам боловсруулж, хэрэгжүүлж ирсэн байна. Монгол улсын хувьд гадаад худалдааг дангаар хариуцан ажилладаг яам байхгүй, одоогоор Монгол улсын гадаад худалдааны бодлогыг Гадаад харилцааны яамны “Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар” хариуцан ажиллаж байна. Иймд Монгол улсын гадаад худалдааны бодлогыг олон улстай харьцуулах замаар гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлыг тодорхойлохыг зорилоо.

Энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Сүүлийн жилүүдэд худалдааны салбарын эзлэх хувь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувиас 2 дахин их байна. Иймд гадаад худалдааг эдийн засгийн өсөлтийг дэмжих хангалттай түвшинд хүргэх, түүнд шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

2. Манай улсын гадаад худалдааны иж бүрэн, нэгдсэн бодлого тодорхойлогдоогүй, гадаад худалдааны гүйцэтгэл, идэвхжилт, хэрэгжилтийн үр дүн тун хангалтгүй байна. Тухайлбал гадаад худалдааны бодлогын үр дүнг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох урсгал тэнцлийн алдагдал, экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс, төгрөгийн доллартай харьцах ханш зэрэг нь олон улстай харьцуулахад хангалтгүй байна. Түүнчлэн гадаад худалдааны бодлогын хэрэгслийг тодорхойлогч худалдааны гэрээ хэлцлийн ач холбогдол, хамгаалалтын хэмжүүр зэрэг үзүүлэлтүүдээр манай улсын худалдааны бодлогын хэрэгслийн хэрэглээ, ач холбогдол бага байна.



**Д.Ган-Очир**

*Судалгаа, статистикийн газрын захирал*  
Монголбанк

---

**Гадаад худалдааны эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө өндөр байхад бодлогыг хэрэгжүүлэх институцийн чадавх, хүний нөөцийн чадавх, болон оновчтой тодорхойлогдсон бодлого зэрэг нь чухал ач холбогдолтой.**

---

3. Засгийн газраас сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх, тэр дундаа уул уурхайн бус салбарын экспортыг бодитой дэмжих цаашлаад экспорт, импортын нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд нэлээдгүй бодлого, хөтөлбөр баталсан хэдий ч үр дүн муутай, биелэлт сайтай бодлого, хөтөлбөр бараг алга байна.

4. Монгол улсад Гадаад худалдааг хөгжлийн бодлогын нэг гол тулгуур болгож амжилттай хэрэгжүүлж ирсэн улс орнуудад байдагтай адил гадаад худалдааг дэмжих, худалдааг хөнгөвчлөх институцийн орчин бүрдээгүй бөгөөд эдгээрийг хослуулан ашиглаж, чиг үүргийг хэрэгжүүлж чадахгүй байна.

5. Өмнөд Солонгос, Чили, Хятад зэрэг худалдааны сайн бодлоготой улсуудын туршлагаас харахад гадаад худалдааны бодлогыг шат дараатай, тогтвортой хэрэгжүүлж ирсэн бөгөөд гадаад худалдааг хариуцсан яам, түүний дэргэд экспортыг дэмжих тусгай байгууллага ажиллуулах замаар өөрийн улсын экспортыг дэмждэг байна.

6. Ихэнх улс оронд гадаад худалдааг дангаар хариуцан ажилладаг яам, түүний дэргэд гадаад худалдааг дэмжих зохицуулалттай бие даасан байгууллага ажиллаж байна. Манай оронд гадаад худалдааг дангаар хариуцсан яам байгуулах шаардлагатай байна. Гэхдээ яам байгуулагдаж хүнд суртал нэмдэг бус, харин худалдааг дэмжих, хөнгөвчлөх чиглэлд анхаарах нь чухал. Гадаад худалдааг дангаар хариуцах яам бий болсноор төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц сайжрах, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийгдэх, үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой.

Анхаарал хандуулсанд баярлалаа !



Монгол улсын хөгжлийн зам нь “худалдаачин үндэстэн” болох явдал билээ. “Худалдаачин үндэстэн” гэдэг нь аливаа улс орнуудтай ашигтай худалдаа эрхэлж чаддаг улсыг хэлнэ. Үүний тулд бид дараах зүйлсийг хийх хэрэгтэй байна. Үүнд:

1. Үйлдвэрлэл, худалдаа хоёрыг сөргүүлэн тавьдаггүй болох буюу үйлдвэрлэл сайн, худалдаа муу гэсэн ойлголтыг халах.
2. Монгол улсын хувьд худалдааг дэмжих, худалдааг хөнгөвчлөх асуудлыг хамгийн сайн хийх.
3. Худалдаа бол хөгжил авч ирдэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн төрийн бодлоготой байх зэрэг багтана.

Монгол улс далайд гарцгүй орон боловч бид 2 том зах зээлд гарцтай. Бидний байршил гадаад худалдааг хийхэд давуу талтай ч байж болох тул үүнийг сул тал гэж харах нь өрөөсгөл ойлголт билээ. Непал улс мөн адил далайд гарцгүй орон хэдий ч худалдааны салбараа хөгжүүлж чадсан. Иймээс бид гадаад худалдааны асуудлыг, тэр дундаа хилийн худалдааны асуудлыг анхаарах хэрэгтэй. Статистик тоо мэдээнээс харахад баруун 5 аймгийн инфляци ямагт өндөр байдаг. Үүнийг бид хилийн худалдааны асуудалтай холбоотой тайлбарлаж болно.

Манай улс шиг жижиг нээлттэй эдийн засаг бүхий улсын хувьд уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх шаардлага бий.

Эцэст нь хэлэхэд гадаад худалдаа нь эдийн засгийн хөгжилд шууд нөлөөтэй. Мөн бидэнд гадаад худалдааны яам хэрэгтэй байж болно. Гэхдээ энэ яам нь хүнд суртлыг нэмэгдүүлэх ёсгүй, харин худалдааг дэмждэг, хөнгөвчилдөг, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг хийдэг байх ёстой. Түүний үр дүнд бизнес эрхлэгчид хождог болох юм. Австрали зэрэг өндөр хөгжилтэй орнуудад гадаад харилцааны яам нь гадаад худалдааг дангаар хариуцдаг. Бид одоогийн гадаад худалдааг хариуцаж буй институцийн чадавхийг сайжруулах, эсвэл шинээр яам байгуулах арга замын алийг нь ч сонгосон, эдийн засгийн хөгжилд гадаад худалдаа чухал үүрэгтэй гэдэг талаас нь харж сайжруулах хэрэгтэй байна.

Анхаарал тавьсанд баярлалаа!



### **С.Дэмбэрэл**

*Эдийн засгийн судалгаа,  
сургалтын хүрээлэнгийн  
захирал*

Монголбанкны дэргэдэх

---

**Монгол улс  
“худалдаачин  
үндэстэн” байх  
ёстой.  
“Худалдаачин  
үндэстэн” гэдэг  
нь хөгжлийн  
тэргүүлэх  
чиглэл билээ.**

---

Монголбанкнаас дэвшүүлж буй шинэ яам байгуулах тухай санаа нь зөв боловч учир үл мэдэх эрх баригчдын буруугаас болж гадаадын хөрөнгө оруулагчдыг зах зээлээс шахан гаргаж болзошгүй. Монгол улсад эрх баригчид ерөнхийдөө монополь эрх мэдлийг бий болгох хандлагатай байдаг.

Одоо хэлэлцэж буй гадаад худалдааны асуудал нь товчхондоо Монголчууд тэнгэрээс газарт бууж байгаатай адил үзэгдэл юм. Нэг хэсэг бүгд үйлдвэрлэгч орон болох тухай ярьдаг байсан. Гэтэл манайх шиг хүн ам цөөнтэй оронд худалдааны салбараа хөгжүүлэх нь илүү зохимжтой юм. Өөрөөр хэлбэл, хөрсөн дээрээ бууна гэдэг нь худалдаачин үндэстэн болохыг хэлнэ. Сингапур, Хонг Конг зэрэг орнууд анх худалдааны хаб (төв) байсан бол эдийн засаг хөгжихийн эрхээр санхүүгийн хаб болсон байдаг.

Эцэст нь хэлэхэд, шинээр санаачилж буй яамыг буруугаар эргүүлж худалдааны монополийг бий болгох эрсдэл бий. Мөн худалдаачин үндэстэн болохын тулд төр засаг, ард иргэд бүгд цогц мэдээлэлтэй болох хэрэгтэй.



**М.Энхсайхан**  
Ерөнхий сайд асан



**С.Болдхэт**  
ТУЗ-ийн дарга  
Наран Трейд ХХК

Шинээр санаачилж буй яамыг зөв цогцлоохгүй бол ерөнхий сайд асан М.Энхсайханы хэлсэнтэй адил хүнд суртлын ахиад нэг аппарат үүсэж болзошгүй. Заавал шинэ яам байгуулах шаардлагатай бол тус яам нь мэдээлэл өгдөг, Монгол бараа бүтээгдэхүүнийг зах зээлд хэрхэн гаргах талаар судалгаа, шинжилгээ хийдэг байх нь чухал. Өөрөөр хэлбэл, бодлогын яамтай болох хэрэгтэй.

Импортыг хүмүүс их шүүмжилдэг. Гэтэл манай улсад үйлдвэрлэл эрхлэх боломж хомс байдаг. Иймээс бид өөрсдөө үйлдвэрлэж чаддаг арьс шир, ноос ноолуур зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрийг л хөгжүүлэх шаардлагатай байна.

Эцэст нь хэлэхэд, шинээр гадаад худалдааны яам байгуулахаар бол бизнес эрхлэгчидтэй санал зөвшилцөж, зөв бодлогын яамыг бий болгох нь зүйтэй. Хэрэв ийм яамыг үүсгэх боломжгүй бол заавал шинээр яам байгуулахгүйгээр одоо байгаа агентлагуудыг сайжруулах тал дээр арга хэмжээ авах хэрэгтэй юм.

Бидэнд шинэ яам байгуулах шаардлага байхгүй. Харин худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид нь Худалдаа аж үйлдвэрийн танхим дээр илүү төвлөрч ажиллах нь зүйтэй юм. Төр засаг их хурдацтай солигдож байна. Энэ нь бодлогын хэрэгжилт, хяналт зэргийг явуулахад сөрөг нөлөө үзүүлдэг. Иймээс худалдаа, үйлдвэрлэлийг хийж чаддаг хүмүүст зохицуулах эрх мэдлийг өгөх нь илүү үр ашигтай байна.

Монголчууд үйлдвэрлэл эрхлэхэд хэтэрхий ухаантай ард түмэн юм. Заавал аливаа зүйлийн арга эвийг олж, технологийг өөрчилдөг. Тэгэхээр бидэнд үйлдвэрлэл зохихгүй билээ. Мөн комерц гэдэг гадаад үгийг худалдаа гэж орчуулах нь учир дутагдалтай тул үүнийг зөв орчуулж, нэгдсэн ойлголтонд хүрэх шаардлага бий.



**Ч.Амарбаатар**  
Ерөнхийлөгч  
Барс групп

Зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш 30 жилийн турш худалдааг ямар нэг хууль, зохицуулалтгүй хийж ирсэн. Үүний үр дүнд худалдааны алдагдал өндөр түвшинд хүрсэн. Бид худалдааг хөгжүүлж байж үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжлийн талаар ярих нь зөв юм. Гадаад худалдааны асуудлыг бүрэн шийдээгүй байхдаа үйлдвэрлэлээ өсгөхөөр татаас өгөх нь үр ашиг багатай.

Бизнес эрхлэх хугацаанд төр засгаас надад огт дэмжлэг үзүүлж байгаагүй. Жишээлбэл миний бие саяхан Москва хотод болсон олон улсын яармаг худалдаанд оролцсон. Тэнд бүх улсын элчин сайд, гадаад худалдааны байгууллагууд ирсэн. Гэтэл манай улсын төрийн байгууллагын оролцоо хангалтгүй байсан. Тус яармаг худалдаанд манай махан бүтээгдэхүүн шагнал хүртсэн бөгөөд хэрэглэгчдэд газар дээр нь бүтээгдэхүүнийг их хэмжээгээр худалдаж чадсан.

Иймд төр засгаас хийж чаддаг хүмүүст нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.



## Л.Ганпүрэв

*Дэд ерөнхийлөгч*  
Монголын уул уурхайн бус экспортлогчдын үндэсний холбоо



## Б.Санжмятав

*Зөвлөх дэд профессор*  
Монгол улсын их сургууль

Монгол улс бол жижиг нээлттэй эдийн засагтай, цөөн хүн амтай улс. Иймээс улс орон хөгжих нэг үндэс нь худалдааны салбар юм. Би дараах гол 6 санааг дэвшүүлж байна. Үүнд:

1. Бүс нутгийн интегралчлал сүүлийн жилүүдэд хамгийн их хөгжиж байна. Бид үүнд нэгдэхгүй бол бүтээгдэхүүн байгаад ч зарах боломжгүй болно.
2. Бид олон улсын жишиг бодлогыг дагасаар байгаад өөрийн гэсэн бодлогогүй болсон. 2008 оны 12-р сард болсон “Их 20”-ийн уулзалтаар дэлхийн хэмжээнд цаашид төрийн зохицуулалттай зах зээлийн нийгэм хөгжинө гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг.
3. Аливаа улс орон хөгжлийн бодлогоо тодорхойлохдоо эхлээд стратеги боловсруулах ёстой.
4. Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д Монгол улс элссэнтэй холбоотойгоор Засгийн газар худалдааны зохицуулалтын эрхийг ДХБ-д бүрэн шилжүүлж өгдөг. Үр дүнд нь манай орны гадаад худалдаатай холбоотой хууль тогтоомжийн тоо харьцангуй цөөн байх магадлалтай.
5. Бид чөлөөт худалдааны хэлэлцээр хэрэгтэй гэдгийг ойлгосон боловч хэлэлцээр хийх мэргэжлийн баг алга байна.
6. Худалдааны яам зайлшгүй шаардлагатай байна. Энэ яам нь бодлогыг тодорхойлж, зохицуулж, мэдээлэл өгдөг байх нь чухал. Мөн худалдааны хуулийг гаргаж, эрхзүйн орчинг хуулиндаа тодорхой тусгах хэрэгтэй.

Гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэхэд бизнес эрхлэгчид болон ТББ-ын оролцоо чухал үүрэгтэй. Бид зорилгоо дэлхийн эдийн засагтай хөл нийлүүлэн тодорхойлж байж бодлогоо боловсруулах ёстой. Дэлхийд ирээдүйд мэдлэг, мэдээллийн зах зээл хөгжихөөр байна. Монголчууд заавал гар ашигладаг үйлдвэрлэл хөгжүүлэх хэрэггүй. Өнөөдрийн бидний үйлдвэрлэл буй бүтээгдэхүүнүүд ямар ч өрсөлдөх чадваргүй бөгөөд логистикийн тал дээр асуудалтай байдаг. Харин мэдээллийг худалдаалдаг зах зээлд өрсөлдөх нь зүйтэй. Монгол хүний оюуны потенциалыг ашиглаж мэдлэгийн экспортыг хөгжүүлэх боломжтой юм. Монгол улс мэдээллийн хаб орон болж болно.

Эцэст нь нэмж хэлэхэд бид гадаад худалдааны бодлогыг дэлхийн худалдааны маргаанаас хэрхэн ашиг олж болох талаас нь харж, боловсруулах хэрэгтэй.



## Б.Хаш-Эрдэнэ

*Зөвлөх*  
Дэлхийн банкны экспортыг дэмжих төсөл



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК